

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2018.04.24-2018.05.24/

УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Аймгийн Засаг даргын нэрэмжит “Боржигон түмний дуулал-2018” урлагийн наадамд 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэн 12 төрлөөр оролцож “Тэргүүн байр” эзэллээ.



Сумын Засаг даргын 2018 оны 04-р сарын 22-ны өдрийн А/50 дугаар захирамжаар сумын хэмжээнд Цэргийн ээлжит татлага зохион байгуулах комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан цэрэг татлагын ажлыг 2018 оны 04 сарын 23-ны өдөр зохион байгуулж цэргийн насны 86 иргэн хамрагдаж цэрэг татлага 78,2 %-ийн гүйцэтгэлтэй хамрагдлаа.

Сумын Засаг даргын 2018 оны 04-р сарын 18-ны өдрийн А/46 дугаар захирамжаар Тээврийн хэрэгслийн улсын үзлэг тооллогыг зохион байгуулах комиссыг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж 2018 оны 04-р сарын 23-26-ны хооронд зохион байгуулж нийт 292 авто машин тээврийн үзлэгт хамрагдсан.

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан сумын ЗДТГ, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран “ГЭР БҮЛИЙН АЗ ЖАРГАЛ ӨДӨРЛӨГ”-ийг 2018 оны 05-р сарын 09-ний өдөр зохион байгуулж гэр бүл судлаач, магистер, доктор Б.Шүхэрцэцэг сумын 95 иргэнд “Гэр бүлийн үнэ цэнэ” лекцийг тавьж, зорилтот бүлгийн 2 өрхөд зөвлөгөө өгч ажилласан. Мөн сумын шилдэг 5 гэр бүлийг шалгаруулж “Өргөмжлөл” дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан. Үүнд:

1. Авъяаслаг гэр бүлээр Боохуузын Хүдэр
2. Спротлог гэр бүлээр Оюундамбын Төгөлдөр
3. Үлгэр жишээч гэр бүлээр Санжийн Чангаа
4. Бүтээлч гэр бүлээр Цэндийн Нэргүй
5. Оюунлаг гэр бүлээр Шагдаржавын Жанчив

Тус өдөрлөгөөр авъяаслаг гэр бүл шалгаруулах “Хослон дуулья” дууны тэмцээнийг зохион байгуулж 1, 2-р байрыг шалгаруулан 1-р байранд Л.Цэрэн-Очир гэр бүл, 2-р байранд Ч.Сугармаагийн гэр бүл шалгарч “Өргөмжлөл” дурсгалын зүйлээр шагнагдлаа.



Сумын ИТХ, ЗДТГ болон аж ахуй нэгж байгууллагуудын “Иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөг”-ийг 2018 оны 05-р сарын 10-ны өдөр сумын төв талбайд зохион байгуулж нийт 9 байгууллагын 43 албан хаагч оролцож, давхардсан тоогоор 579 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлж, 1300 гарын авлага тарааж, 5 өргөдөл, гомдол, санал, хүсэлт хүлээн авч газар дээр нь шийдвэрлэн ажилласан. Мөн өдөрлөгт аймгийн Татварын хэлтэс оролцож иргэдэд мэдээ мэдээлэл хүргэж иргэдийн дунд АХА тэмцээн зохион байгууллаа.



Сумын Засаг даргын 2017 оны А/121 тоот захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу төсвийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудад 2018 оны 05-р сард хяналт шалгалт хийж арга зүйн зөвлөгөө өгч, зөрчил дутагдалыг арилгуулах талаар зөвлөмж хүргүүлэхээр ажиллаж байна.

ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2018 оны 05-р сарын 25-ны өдрийн байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт /мянган.төг/	Зардлын гүйцэтгэл /мянган.төг/
1.	ИТХ	18221500	15733881
2.	ЗДТГ	132030500	122672470

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.


№	Байгууллагын нэр	Санхүүжилт /төгрөгөөр/	Зардлын гүйцэтгэл /төгрөгөөр/
1.	Эрүүл мэндийн төв	143773900	126407453
2.	Соёлын төв	25369600	24910200
3.	3-р сургууль	309333600	292267392

4.	3-р цэцэрлэг	174115100	158897630
----	--------------	-----------	-----------

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө тайлант хугацааны өссөн дүнгээр 19292,8 мянган төгрөг, гүйцэтгэл 13603,3 төгрөг буюу 71 хувийн биелэлттэй байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Хууль зүйн орон тооны бус албаны 2018 онд зохион байгуулах эрх зүйн албан бус сургалтын хуваарийн дагуу 2018 оны 04-р сарын 23-ний өдөр “Цэргийн албаны тухай хууль”-иар сумын цэргийн насны залуучуудад, мөн аймгийн Хууль эрх зүйн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсүүдтэй хамтран “Зөрчлийн тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль”-иар тус тус суралт зохион байгуулж нийт 129 иргэн хамрагдлаа.




Аймгийн хуулийн байгууллагуудын “Иргэдээ сонсьё” аяны хүрээнд “Хууль сурталчлах өдөрлөг”-ийг 2018 оны 05 дугаар сарын 16-нд хамтран зохион байгуулж 156 иргэнд үйлчилгээ үзүүлж, 108 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч, 329 иргэнд гарын авлага тараасан бөгөөд 3 дугаар сургуулийн 10, 11 дүгээр ангийн сурагчдын дунд зохион байгуулсан “Алтан хонх” тэмцээнд 11а ангийн сурагч Л.Хонгорзул түрүүллээ.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ :

“САЙН БАГШИЙН САЙН ШАВЬ” арга хэмжээг зохион байгуулж I - V ангийн нийт 400 сурагчдаас Монгол хэлний хичээлээр унших чадварын шалгалтыг авч үр дүнг нэгтгэлээ.



2017-2018 оны хичээлийн жилд шинээр нэгдүгээр ангид элсэн орсон 85 сурагч “Эрдмийн баяр”-аа тэмдэглэн өнгөрүүлээ.

3 дугаар Сургуулийн 126 ангийн нэрэмжит сагсан бөмбөг, гар бөмбөгийн тэмцээнийг сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж нийт 13 баг оролцосноос эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа.

“Бяцхан судлаач” төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийг сайжруулах зорилгоор бага ангийн багш нарын дунд “**Бид судлаачдыг хөгжүүлнэ**” уралдааныг зохион байгуулж, нийт бага ангийн 12 багш, 400 суралцагч, 200 гаруй эцэг эхчүүд хамрагдан “**Бяцхан судлаач**” кабинетэд гарын доорх материал ашиглан 500 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт бүхий баяжилт хийлээ.

Монголын Матеметикийн багш нарын Академи, Математик сэтгүүлтэй хамтран зохион байгуулсан “**Ирээдүй мянгат – 2018**” улсын математикийн уралдаанд 3-р сургуулийн бага ангийн сурагчид амжилттай оролцож 23 медаль хүртлээ.

Говьсүмбэр аймгийн хөнгөн атлетикийн аварга шалгаруулах тэмцээнд 6 төрлөөр 132 сурагчид өрсөлдсөнөөс 3-р сургуулийн сурагчид 2 мөнгө, 2 хүрэл медаль хүртэж, багаараа 3 дугаар байранд шалгарсан.

МУ-ын гавьяат багш Н.Түмэн-Өлзийн нэрэмжит “Монгол бичиг”-ийн олимпиадад 1 багш, 5 сурагч шагналт байруудад шалгарлаа.

“Хамтран ажиллаж харилцан суралъя” өдөрлөг-ийг 1-5 дугаар ангийн эцэг, эхчүүдийн дунд зохион байгуулж эцэг, эхчүүд сурагч болж өртөөчилсөн хичээлд хамрагдлаа.

Говьсүмбэр аймгийн Политехник коллежоос зохион байгуулсан “Охид хөвгүүдийн өдөрлөг”-т 19 сурагч оролцсон бөгөөд “Алтан хонх” хөгжөөнт тэмцээнд 10а ангийн сурагч Бүдрагчаа 1 дүгээр байр, Нармандах 2 дугаар байр эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

2018 оны 05 дугаар сарын 15-ны өдөр 9а,б ангиуд “Төгсөлтийн тайлант өдөрлөг” зохион байгуулж багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эхчүүддээ тоглолт хийж, ангийн шилдгүүдээ шалгаруулж шагнаж урамшууллаа.

Энэ хичээлийн жилд нийт ахлах, дунд ангийн 161 сурагч төгсөж байгаа бөгөөд 2018 оны 05 сарын 16-ны өдөр төгсөгчдийн “Эрдмийн баяр”-ыг тэмдэглэн өнгөрүүлээ.



“Бяцхан судлаач” тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1-5 дугаар ангийн 400 суралцагчийг өөрийн орон нутгийн түүхэн дурсгалт газруудтай танилцуулах аялалыг 2018 оны 05 дугаар сарын 17 -нд зохион байгууллаа.



3-Р ЦЭЦЭРЛЭГ

Цэцэрлэгийн 9 бүлгийн 221 хүүхдийн эцэг эхийн дунд хэрэглэгчийн үнэлгээг цэцэрлэгийн ЗАН-ээс хийж, үнэлгээгээр нийт эцэг эхийн 89% нь багш болон туслах багш нарын харилцааг хангалттай сайн, хүүхдийн хөгжлийг сайн хөгжиж байна гэж үнэлсэн. Үнэлгээг 8 асуулгаар явуулж Ц. Батчимэг, Э.Цэцэгмаа багштай Бэлтгэл бүлгийн үнэлгээ 100% үнэлэгдэж цэцэрлэгийн хэмжээнд хамгийн сайн үнэлгээг авсан.

Аймгийн “бид бяцхан хөгжимчид-2018” уралдаанд оролцож 3-р байр, “Замын хөдөлгөөний цагаан толгой-2018” уралдаанд оролцож 2-р байрыг тус тус эзэллээ.

“Шивээ-овоо” ХК-ийн хөрөнгө оруулалтаар цэцэрлэгийн хүүхдийн тоглоомын талбайн тохижилтыг хийж эхлээд байна.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эмнэлэгт хэвтсэн- 50 үүнээс хүүхэд- 15
- Амбулаторийн үзлэг – 770
- Урьдчилан сэргийлэх- 191
- Дуудлага-149

Төрийн албан хаагчдыг зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн хянах ажлын хүрээнд 2018 оны 05 сарын 05-06-ны өдрүүдэд Улсын төв 1-р эмнэлгийн эмч нарыг урьж ирүүлэн төрийн албан хаагчдад Нүд, Чих хамар хоолой, Эмэгтэйчүүд, ЭХО, Дотор, Мэс засал, Мэдрэл гэсэн нийт 7 төрлийн нарийн

мэргэжлийн эмчийн үзлэгт 8 байгууллагын 160 гаруй ажилтан, албан хаагчдыг үзлэгт хамрууллаа.

3-р Сургуулийн 1-р ангийн 26 хүүхдэд Хараа хамгаалах, гарын ариун цэвэр сахих, амны хөндийн эрүүл мэндийн талаарх сургалтыг зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хүүхэд бүрт амны хөндийн үзлэг, хараа шалгах картыг нээж картжуулан ажилласан.

Нярай хүүхдүүдтэй ээжүүдэд нярайн асаргаа сувилгаа сэдэвт сургалтыг 05-р сарын 11-ны өдөр зохион байгууллаа.

Дэлхийн тамхигүй өдрийг тохиолдуулан “Тамхи зүрхэнд хортой тамхийг биш эрүүл мэндээ сонгоё” аян зарлаж аяны хүрээнд 3-р сургуулийн дунд ангийн сурагчидад тамхины хор хөнөөл, түүнээс урьдчилан сэргийлэх сургалтыг 05 сарын 17-ны өдөр зохион байгуулсан. Мөн гэр бүлийн тамхи татдаг хэн нэгэндээ хандаж бичих Захидалын уралдааныг зарлан ажиллаж байна.

Сумын иргэд Эрүүл мэндийн төвд хүүхдийн судас тодосгогч аппарат авах аян өрнүүлсэнээр 2018 оны 05 дугаар сарын 18-нд иргэдийнхээ сэтгэлийн хандиваар 660.000 төгрөгийн үнэтэй “Судас тодосгогч аппарат” авч эрүүл мэндийн төвийн хамт олонд гардууллаа.



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2018 оны 05-р сарын 09, 11 өдөр зохион байгуулан 5 иргэний өргөдлийг шийдвэрлэн мөнгөн тэтгэмжид хамрууллаа. Мөн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгох “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах 6 төсөл, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах 1 төсөл, “Ахмад настаны ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах 1 төсөл нийт 8 төслийг хэлэлцэн дэмжиж ХХҮГ-т хүргүүлсэн. Үүнд:

“Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт хамрагдах иргэд:

1. Өлзийбаяр овогтой Урнаа
2. Сэрдамба овогтой Алтантуяа
3. Үрчгэр овогтой Болор-Эрдэнэ
4. Равжир овогтой Хатантөмөр
5. Шар овогтой Нансалмаа
6. Берквай овогтой Аманбек

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт Даариймаа овогтой Баатархүүгийн төслийн шалгуур үзүүлэлтийг хангаж дэмжигдлээ.

“Ахмад настаны ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэгт Цэдэн овогтой Даваасүрэнгийн төсөл шалгуур үзүүлэлтийг хангаж дэмжигдлээ.

Асаргааны мөнгөн тэтгэмжид 4 иргэн, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 2 иргэнийг хамрууллаа.

“АЮУЛГҮЙ АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ” ХАБЭА-н сарын аяныг төлөвлөгөөний дагуу 2018 оны 4-р сарын 27-ны өдөр сумын Засаг даргын Тамгын газар, 3-р цэцэрлэг, 3-р сургуулийн 51 ажилтан, албан хаагчдад ХАБЭА-н анхан шатны мэдлэг олгох сургалтыг зохион байгууллаа.

Шинээр нээлгэсэн хувийн хэрэг болон хөнгөлөлт, тусламж, сунгалт хийлгэсэн иргэдийн материалы программд оруулан баталгаажуулж 13 иргэд 1172050 төгрөгийг олгосон.

2018 оны 5-р сард жирэмсэн – 28 эхэд 1120000 төгрөг 0-3 насны хүүхдээ асарч байгаа 182 эхэд 9100000 төгрөгийн мөнгөн тэтгэмжийн олгосон.

Ажил хайгч 5 иргэнийг бүртгэж программд оруулж, 5 иргэнийг “Шивээ-Овоо” ХК-д ажилд зуучалж, ямаа самнах 25 иргэнийг цагийн ажилд зуучиллаа.

НИЙГМИЙН БОДЛОГО

2018 оны 05 сарын 04-ний өдөр сумын Засаг даргын Захирамжаар томилогдсон ажлын хэсэг тус сумын 2-р багийн 21-р зөрлөгт үйл ажиллагаа явуулдаг хүүхэд харах үйлчилгээний “Солонго” төвийн ажлын байртай танилцаж, хүүхэд харах үйлчилгээний байрны үнэлгээний хуудсын дагуу үнэлгээ өгч, зөвшөөрөгдөх хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна гэж дүгнэлээ.



Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд “Байгаль бидний гэр” аянг зарлаж, нийтийн эзэмшлийн ногоон байгууламжинд 20 ширхэг улиас тарилаа.

Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд байнгын асаргааны 27 иргэнийг хаврын витаминжуулалтанд хамруулж ажилласан.

Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд 4 байгууллагын 81 ажилтан, албан хаагчдыг хамруулсан.



УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 2018 оны 04 дүгээр сарын 22-ноос 2018 оны 05 дугаар сарын 21-ны байдлаар 92 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 15 иргэнийг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийлгээд байна.

2018 оны 05-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 2 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Эхний 5 сарын өссөн дүнгээр 19 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аваад байна.

2018 онд 1973, 1993 оны иргэд 25 болон 45 насны сунгалт хийлгэх, 2002 оны хүүхдүүд 16 нас хүрч шинээр иргэний үнэмлэх захиалах талаарх мэдээллийг фэйсбүүк болон мэдээллийн самбар, нээлттэй хаалганы өдөрлөгөөр сурталчлан ажиллаж байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2018 ОНЫ 05 САРЫН МЭДЭЭ

	м/ д	Бүг д	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	37				37	16	21
Төрсөн эх	2	37				37		37
Бүртгүүлсэн гэр бүл	3	15				15	15	15
Нас баралт	4	7				7	3	4
Цуцалсан гэр бүл	5	5				5	5	5
Үрчлэгдсэн хүүхэд	6	1				1	1	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	53				53	23	30
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	42				42	26	16

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС ОРСОН ОРЛОГО

д/д	Үйлчилгээний нэр төрөл	2018 оны 05-р сар				Бүг д	Тай лба р	
		Үйлчилгээний хураамж 30020002210 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ			Тоо
1	эцэг тогтоосны бүртгэл	2500	4	10000				
2	Гэрлэлтийн гэрчилгээ	2500	3	7500				
3	Гэрлэлт цуцлалтын гэрчилгээ	2500	2	5000				
4	Төрсний гэрчилгээ дахин олголт	5000	3	15000				

5	Иргэний үнэмлэх	15000	17	255000	3300	17	56100	
6	Өөр аймаг шилжин явсан	2500	11	27500	1000	11	11000	
7	Аймаг доторх шилжилт хөдөлгөөн	1500	5	7500	1000	5	5000	
ДҮН		327500			72100			
НИЙТ ДҮН		399600						

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Сумын хэмжээнд нийт 20664 мал төллөхөөс 2018 оны 05-р сарын 21-ний өдрийн байдлаар 15937 толгой мал төллөж, мал төллөлт 77.1%-тай байна.

Сумын Засаг даргын 2018 оны А/49 дугаар “Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга хийх тухай” захирамжийн дагуу 2018 оны 04 дугаар сарын 24-ны өдрөөс “Шүлхий” өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарилгын ажил эхэлж нийт 71 өрхийн 111 тэмээ, 1663 үхэр, 26868 хонь, 39566 ямаа, 44 гахай нийт 68252 толгой мал хамрагдсан. Мөн төлийн давтан вакцинд 18 өрхийн 81 тугал, 2677 хурга, 1967 ишиг хамруулаад байна.

МЭУТасаг нь Улсын Мал эмнэлэг ариун цэврийн лаборатори, аймгийн ХХААГ-тай хамтран сумын 16 өрхийн 200 толгой малаас шүлхий өвчний вакцины дархлаа, байгалийн халдварлалтыг тогтоох цусны дээж авах ажлыг зохион байгуулж ажилласан.

БАЙГАЛЬ ОРЧИН

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 28 ААНБ-ын 146 иргэн 19,2 м3 хог хаягдлыг түүж цэвэрлэн төвлөрсөн хогийн цэгт ачиж зайлуулсан.



Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу “Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг 05 сарын 11, 12-ны өдрүүдэд зохион байгуулж 10 аж ахуйн нэгж байгууллага нийт 4 төрлийн 429 мод бутыг шинээр тарьсан.



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН

2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил үйлчилгээний саналыг 957 өрх буюу сумын нийт өрхийн 89,6 хувиас авч 1, 2-р багийн Иргэдийн нийтийн хурлыг 2018 оны 05 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион байгуулж эрэмбэлүүлсэн бөгөөд сумын Засаг даргын 2018 оны А/47 захирамжаар байгуулагдсан “Төсөл, арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөмж өгөх” ажлын хэсэг хуралдаж нэгдсэн жагсаалтыг боловсруулаад байна.

“Соёлын төвийн дулаан, цэвэр усны шугамыг сольж шинэчлэх” ажлыг “Чандмань” иргэдийн бүлэгтэй 4985700 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ашиглалтад хүлээн авах улсын комисс ажиллуулсан.

“Зүүн гэр байрны ундны усны худгийг цахимжуулах, зүүн гэр хорооллын худгийн байрыг засварлах” ажлыг “Сүмбэр зууч” ХХК-тай 9.800.000 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн бөгөөд ажлын явц 50 хувьтай байна.

“3 дугаар цэцэрлэгийг тохижуулах/гэр, зөөлөн эдлэл” худалдан авах барааг “Мөнх авзага хайрхан” ХХК-тай 5.800.000 төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулаад байна.

Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжуудад бут, сөөг тарих, усалгаа, арчилгаа, хамгаалалт хийх, цэцэрлэгт хүрээлэнг цэцэгжүүлэх” ажлыг “Илчлэг-Шивээ” ОНӨҮГ-тай 2.000.000 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулаад байна.

Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн урсгал засвар, үйлчилгээ хийх ажлыг “Энхжих формат” ХХК-тай 5.747.800 төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулаад байна.

Сумын төвийн гудамж, талбай, албан байгууллага, айл өрхийг үе шаттайгаар хаягжуулах ажлыг “Их эффект” ХХК-тай гэрээ байгуулахаар албан бичиг хүргүүлээд байна.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ДАХОХААХМэргэжилтэн

С.Банзрагч